

**ОЛОН ХҮҮХЭД ТӨРҮҮЛЖ ӨСГӨСӨН ЭХИЙГ УРАМШУУЛАХ
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ
ЭЦСИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААРХ ХҮНИЙ ХӨГЖИЛ,
НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТАНИЛЦУУЛГА**

2026 оны 05 дугаар
сарын 19-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Х.Баасанжаргал, Б.Баярбаатар, Б.Уянга, С.Эрдэнэбат, С.Эрдэнэболд нарын гишүүдээс 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурал 2026 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу явуулсан бөгөөд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара олон улсын гэр бүл олширч буй өнөөгийн нөхцөлд Монгол Улсын иргэнтэй гэр бүл болж, хүүхэд төрүүлсэн гадаад улсын эхчүүдийг урамшуулах эрх зүйн зохицуулалтыг хэрхэн шийдвэрлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл “Эхийн алдар” одон олгох эрх нь хүүхэд амьд төрж, улсын бүртгэлд бүртгэгдэн, төрсний гэрчилгээ авсны дараа үүсэх ёстойг онцлон, хүүхдээ бусдад үрчлүүлсний дараа одон олгох болон урамшууллын эрх давхар үүсэх эрсдэлийг хууль, журмын түвшинд хэрхэн зохицуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен хүүхэд төрсний дараах эндэгдэл, төрөлхийн гажиг, амьдрах чадваргүй төрөлт зэрэг нөхцөлд “Эхийн алдар” одон олгох шалгуурыг хэрхэн тооцох, мөн хуулийн өөрчлөлтийн улмаас халамжийн хүрээ хэт тэлж улсын төсөвт нэмэлт дарамт үүсэх эрсдэлийг судалсан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа “Эхийн алдар” одон олгох үйл ажиллагааны эрх зүйн болон захиргааны зохицуулалт тодорхой бус байгаагаас үүдэн хүүхдийн эндэгдэл, гэрийн төрөлт, үрчлэлт, төрөлтийн дараалал зэрэг олон нөхцөлд маргаан үүсэх эрсдэлтэйг анхааруулж, үрчлэлтийн насны хязгаарыг бүрэн халах нь төсөв, нийгмийн бодлогын хувьд тооцоолоогүй үр дагавар дагуулах эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 3.2 дахь хэсэгт туссан “тэр үед гурав хүртэлх насанд нь” гэснийг төслөөс хасах тухай зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргасныг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3-т заасны дагуу Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн бөгөөд зарчмын зөрүүтэй саналын томъёолол Байнгын хорооны хуралдаанаар дэмжигдсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



П.ГАНЗОРИГ

**ОЛОН ХҮҮХЭД ТӨРҮҮЛЖ ӨСГӨСӨН ЭХИЙГ УРАМШУУЛАХ ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу хураалгах санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “тэр үед гурав хүртэлх насанд нь” гэснийг төслөөс хасах.

Санал гаргасан:Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ОЛОН ХҮҮХЭД ТӨРҮҮЛЖ ӨСГӨСӨН ЭХИЙГ УРАМШУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх ~~жэггээ~~ заалтын “бага хүүхэд нь 1 нас хүрсэн,” гэснийг, 3.2 дахь ~~жэггээ~~ хэсгийн “бага хүүхэд нь 4 нэг нас хүрэхэд” гэснийг, мөн хэсгийн “**тэр үед гурав хүртэлх насанд нь**” гэснийг, “байгалийн аюулт үзэгдэл, осол, өвчин, гэмт хэргийн улмаас” гэснийг, “1 ба түүнээс дээш настай” гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг ~~2026 оны 01 дүгээр сарын 01-ний~~ 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг